



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 01 өдөр

Дугаар

A/362

Хэрлэн сум

“Аян хур” ХХК болон “Хүчит далайн луунууд”
ХХК-ийн тусгай зөвшөөрлийг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батноров сумын нутаг дэвсгэрт орших “Үүц” нэртэй 349.84 гектар талбай бүхий “Аян хур” ХХК-ийн XV-23000049 дугаартай, Баян-Адарга сумын нутаг дэвсгэрт орших “Өндөр уул” нэртэй 228.49 гектар талбай бүхий “Хүчит далайн луунууд” ХХК-ийн XV-23000050 дугаартай түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлүүдийн хугацааг хоёр жилээр сунгасугай.

2. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан тухай ашигт малтмал, газрын тосны болон барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэж, тус аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (Б.Дархантөр), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Б.Сүнгээ) нарт тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Э.Мөнх-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ